МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.10.21 № 73

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Э.БАТШУГАР ТАНАА

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн асуудлаар

Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, оношилгоо, сэргээн засалт, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд цаг алдалгүй хамруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, тусламж, үйлчилгээний уялдаа, хүртээмж, санхүүжилт болон цаашид хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодруулах шаардлагатай байна. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

Асуудал тус бүрээр хэрэгжилт, хүрсэн үр дүн, тулгамдаж буй хүндрэл, цаашид авах арга хэмжээ, хариуцах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр, тооцоог тодорхой тусган, холбогдох судалгаа, тоон мэдээлэл, төсөв, санхүүжилтийн мэдээллийг 2026 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан дүнгээр харьцуулан, хамрагдалтын мэдээллийг боломжтой хүрээнд насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр ангилан ирүүлнэ үү.

Эрт илрүүлэлт, оношилгооны талаар

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/261 дугаар тушаалаар баталсан эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны журмын хоёрдугаар хавсралтад хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан үзлэгийн хүрээнд нурууны муруйлт, хавтгай тавхайг 11 насанд илрүүлэхээр тусгасан байна. Нурууны муруйлтын эрдэм шинжилгээний нийгэмлэг /SRS/ болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан байр суурийн баримт бичигт охидыг 10, 12 настайд хоёр удаа, хөвгүүдийг 13 эсвэл 14 настайд нэг удаа үзэхийг зөвлөсөн байна.

1.Нурууны муруйлт, хавтгай тавхайн илрүүлэлтэд 11 насыг сонгосон, үзлэгийн давтамжийг тогтоосон судалгаа, эмнэлзүйн үндэслэл болон хүүхдийн нас, хүйс, өсөлт хөгжлийн онцлог болон хоёр эмгэгийн ялгаатай байдлыг хэрхэн харгалзан үзсэн талаарх тайлбар болон хавтгай тавхайн хэвийн хөгжлийн онцлогийг эмгэг өөрчлөлтөөс ялгах, нэмэлт оношилгоо, эмчилгээ шаардлагатай хүүхдийг эрт илрүүлэх зохицуулалт болон үзлэгийн нас, давтамжийг дахин үнэлж, журамд өөрчлөлт оруулах эсэх талаарх мэдээлэл;

Уналт таталтын эсрэг эмийн хүртээмжийн талаар

2.Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/407 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоол болон холбогдох нэмэлт,

2026000215

өөрчлөлтийн хэрэгжилтийн хүрээнд уналт таталтын эсрэг эмийн хүртээмжийг хэрхэн хангаж байгаа талаар;

3.Оршин суугаа газраасаа шаардлагатай эмээ авч чадахгүй, эмийн тасалдлын улмаас бусдаас түр зээлэх, хувааж хэрэглэх нөхцөл үүсэж байгаа тухай гомдол иргэдээс ирж байгаатай холбогдуулан эмийн хэрэгцээ, нийлүүлэлт, тасалдал, газар зүйн хүртээмжийн өнөөгийн байдал, тэдгээрийн шалтгаан болон тасралтгүй хангамжийг бүрдүүлэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

4.Эмийн чанар, эмчилгээний үр дүнтэй холбоотой гомдлыг хэрхэн шалгаж байгаа, чанарын хяналт, лабораторийн шинжилгээний үр дүн болон эм хэрэглэж байгаа ч уналт таталт үргэлжилж буй иргэдийн эмчилгээний хяналт, үнэлгээг хэрхэн зохион байгуулж байгаа талаар тайлбар ирүүлэх. Эмийн ханган нийлүүлэлт нэг нийлүүлэгчээс хамаарч байгаа эсэх, нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулах, эмчилгээний хэрэгцээнд нийцсэн эмийн сонголтыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацааны талаар;

Сэргээн засах тусламж, үйлчилгээний талаар

5.Цочмог үеийн эмчилгээний дараах сэргээн засах тусламж, үйлчилгээнд цаг алдалгүй шилжүүлэх, шаардлагатай хугацаанд тасралтгүй хамруулах тогтолцоо хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл ирүүлэх. Тухайлбал, эмчилгээний дараах эхний 3–6 сард сэргээн засах үйлчилгээ шаардлагатай иргэдийн хэрэгцээ, хамрагдалт, хүлээгдэл болон үйлчилгээ тасалдаж буй шалтгааныг хэрхэн үнэлсэн, тэдгээрийг шийдвэрлэхээр ямар арга хэмжээ авч байгаа талаар;

6.Урт хугацааны сэргээн засах үйлчилгээ нь зөвхөн эмнэлэгт удаан хугацаагаар хэвтүүлэх бус, тухайн хүний хэрэгцээнд нийцүүлэн давтан, үргэлжилсэн, шаардлагатай тохиолдолд насан туршид нь үзүүлэх дэмжлэгийг хамрах асуудал юм. Иймд урт хугацааны сэргээн засах үйлчилгээний хамрах хүрээ, үзүүлэх хэлбэр, нэг болон олон мэргэжилтний багийн оролцоог холбогдох эрх зүйн зохицуулалт, стандарт, санхүүжилтэд хэрхэн тусгасан талаар;

7.Эмнэлэг, амбулатори, гэр болон олон нийтэд түшиглэсэн сэргээн засах үйлчилгээг уялдуулах, хүний нөөц, тариф, санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлж буй болон төлөвлөсөн арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, 2027 оны төсвийн төсөлд тусгасан санхүүжилтийн талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.САРАНЧУЛУУН

2026000215